



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/30

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Далх овогт Мягмарсүрэнгийн Эрдэнэтогтоол нь /ЗН78101612/ Сүмбэр сумын 1 дүгээр багт Хадгаламжийн банк ХХК-ийн баруун талд байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 104м² газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул Харчин овогт Хүрэлбаатарын Анхсүрэнд /ЕЙ89102908/ Сүмбэр сумын 1 дүгээр багт Төмөр замчдын хотхон 116 тоотод байрлах 104м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлсүгэй.


2. Хуулийн дагуу эзэмших эрхийг шилжүүлэн авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг иргэн Х.Анхсүрэнд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч буй иргэн Х.Анхсүрэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д үүрэг болгосугай.


4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны А/279 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Засаг даргын 2022 оны
01... сарын 31-ны өдрийн /30... дугаар
захирамжийн хавсралт



Харчин овогт Хүрэлбаатарын Анхсүрэнгийн эзэмшилд
олгож байгаа газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	1	104	4	Гэр бүлийн хэрэгцээ	Төмөр замчдын хотхон 116 тоот

